



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2023/197/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Баталгаат тооцоолол аудит ХХК
Захирал: М.Буянбулган
Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Аохдагчдын өргөн таловь 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 116

тантай _____ ны № _____ т

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН
ДАРГА Г.ОДСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 267 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны А/174 дүгээр тушаалыг үндэслэн 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс аймагт Мал эмнэлгийн газар, сумдад мал эмнэлгийн тасаг байгуулагдсан байна.

2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн "Бүтэц, орон тоо батлах тухай" А/24 дугаар тушаалаар аймгийн Мал эмнэлгийн газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Бүтцийн хувьд захиргаа санхүүгийн болон мал амьтны эрүүл мэндийн алба, мал эмнэлгийн лаборатори, Хутаг-өндөр сумын "Гуртын гүүр"-ний мал эмнэлгийн хяналтын цэг, сумдын мал эмнэлгийн тасаг гэсэн, 59 албан хаагчийг орон тоотой байхаар тогтоосон. Тус газар тайлант 16 сумын төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд 55 мал эмнэлэг үйлчилгээний нэгжтэй мал эмнэлгийн арга хэмжээг хэрэгжүүлэх гуравласан гэрээг байгуулж ажилласан байна.

С/Осч/Урс/Д/С/Э/Н/Э/М

006020124

Аудитын гол асуудал

Мал эмнэлгийн газар нь Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, аймгийн хэмжээний мал эмнэлгийн төр, хувийн хэвшлийн байгууллагыг нэгдсэн бодлогоор ханган, нийтийн эрүүл мэндийг хамгаалах эрхэм зорилгын хүрээнд 2022 онд аймгийн Засаг дарга болон МЭЕГ-ын даргатай 14 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 94.5 хувийн биелэлтэйгээр тайлагнасан.

Тайлан оны санхүүгийн тайланд бруцеллёзын тарилга үйлчилгээний хөлсний 3,308.2 мянган төгрөгийн өглөг, улсын тарилга үйлчилгээний хөлсний 26,142.7 мянган төгрөгийн авлагатай ажиллажээ.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх ~~үндэслэлтэй байвал~~ материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

D:\bichgereg\2023\4\root

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>303,251,476.61</u>	<u>312,087,748.31</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	0.00 -
35	БАРАА МАТЕРИАЛ	296,051,476.61	312,087,748.31
351	Түүхий эд материал	272,069,875.93	283,055,012.93
35110	Тусгай зориулалттай материал	189,796,555.36	186,155,655.36
35130	Эм боох материал	82,273,320.57	96,899,357.57
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	0.00
354	Хангамжийн материал	23,981,600.68	29,032,735.38
35410	Бичиг хэргийн материал	1,702,670.00	1,784,880.00
35420	Аж ахуйн материал	4,129,880.00	4,214,880.00
35440	Түлш, шатах тослох материал	4,125.00	1,482,199.70
35450	Барилгын засварын материал	312,000.00	589,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,832,925.68	20,961,775.68
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
36100	Барааны нөөц	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>385,564,949.04</u>	<u>393,223,089.40</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
371	Урт хугацаат хадгаламж	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	385,564,949.04	393,223,089.40
392	Биет хөрөнгө	315,312,949.11	323,367,089.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	154,513,499.57	154,513,499.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,684,602.03)	(24,432,217.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,852,156.79	122,852,156.79
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,696,559.24)	(48,648,441.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	276,587,571.85	322,372,200.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(204,942,133.89)	(223,058,903.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,836,567.10	69,079,567.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,153,551.04)	(49,310,772.70)
393	Биет бус хөрөнгө	70,251,999.93	69,855,999.93
39301	Програм хангамж	1,980,000.00	1,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(704,000.07)	(1,100,000.07)
39303	Бусад биет бус хөрөнгө	68,976,000.00	68,976,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00

394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>688,816,425.65</u>	<u>705,310,837.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>29,450,900.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	29,450,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>688,816,425.65</u>	<u>675,859,937.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	688,816,425.65	675,859,937.71
512	Хуримтлагдсан үр дүн	636,727,097.95	623,770,610.01
51210	Өмнөх үеийн үр дүн	705,567,093.98	636,727,097.95
51220	Тайлант үеийн үр дүн	(68,839,996.03)	(12,956,487.95)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	52,089,327.70	52,089,327.70
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>688,816,425.65</u>	<u>705,310,837.71</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,524,599,906.87	3,093,294,829.21
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	595,461,671.87	889,556,708.21
120	Нийтлэг татварын бус орлого	595,461,671.87	889,556,708.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	595,461,671.87	889,556,708.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	743,600.00	2,767,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	594,718,071.87	886,789,708.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,929,138,235.00	2,203,738,121.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,286,541,175.00	1,307,492,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,286,541,175.00	1,307,492,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	642,597,060.00	896,245,521.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	619,327,300.00	646,399,320.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,269,760.00	249,846,201.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,592,193,856.50	3,106,251,317.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,592,193,856.50	3,106,251,317.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,385,360,600.42	2,930,141,771.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,435,719.60	579,721,432.00
210101	Үндсэн цалин	463,015,881.60	440,789,796.00
210102	Нэмэгдэл	108,955,198.00	91,227,913.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,464,640.00	26,783,660.00
210104	Урамшуулал	0.00	20,920,063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,476,134.82	80,236,263.76

210201	Тэтгэврийн даатгал	53,647,952.21	52,714,418.37
210202	Тэтгэмжийн даатгал	5,967,955.41	6,188,076.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,619,679.35	7,827,121.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,112,777.39	1,298,536.45
210205	Эрүүл мэндийн даатгал	11,127,770.46	12,208,111.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,080,000.00	69,106,454.22
210301	Гэрэл, цахилгаан	5,920,844.22	4,330,523.22
210302	Түлш, халаалт	28,661,855.78	41,553,331.00
210303	Цэвэр, бохир ус	3,065,300.00	4,790,600.00
210304	Байрны түрээс	18,432,000.00	18,432,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,530,581.00	59,282,915.30
210401	Бичиг хэрэг	6,296,075.00	6,607,660.00
210402	Тээвэр, шатахуун	20,084,296.00	24,291,676.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,674,500.00	6,223,831.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,475,710.00	3,558,750.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	0.00	18,600,997.38
2105	Нормативт зардал	798,363,983.21	1,054,152,973.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	774,080,383.21	1,054,151,183.19
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,283,600.00	1,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,403,422.29	15,925,867.76
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,142,300.00	2,934,387.76
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,021,797.29	2,690,850.00
210604	Урсгал засвар	14,239,325.00	10,300,630.00
2107	Томилолт, зочны зардал	10,558,579.00	9,213,500.00
210702	Дотоод албан томилолт	10,558,579.00	9,213,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	749,072,518.50	1,018,574,426.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	744,029,946.00	1,008,799,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	918,000.00	771,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	401,572.50	487,722.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	7,920,000.00
210807	Газрын төлбөр	123,000.00	164,004.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,439,662.00	43,927,938.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,320,992.78	4,558,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,118,669.22	39,369,488.52
210904	Найдваргүй авлагын алдагдал	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	206,833,256.08	176,109,545.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,056,459.00	80,697,130.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,364,459.00	79,032,130.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,692,000.00	1,665,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	167,776,797.08	95,412,415.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	167,776,797.08	95,412,415.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(67,593,949.63)	(12,956,487.94)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,246,046.40	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,246,046.40	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,246,046.40)	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,929,881,835.00	2,206,505,121.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	743,600.00	2,767,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	743,600.00	2,767,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	743,600.00	2,767,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	743,600.00	2,767,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,929,138,235.00	2,203,738,121.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,286,541,175.00	1,307,492,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,286,541,175.00	1,307,492,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	642,597,060.00	896,245,521.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	619,327,300.00	646,399,320.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,269,760.00	249,846,201.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,925,851,875.00	2,206,505,121.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,925,851,875.00	2,206,505,121.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,719,018,618.92	2,030,395,575.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	583,435,719.60	579,721,432.00
210101	Үндсэн цалин	463,015,881.60	440,789,796.00
210102	Нэмэгдэл	108,955,198.00	91,227,913.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,464,640.00	26,783,660.00
210104	Урамшуулал	0.00	20,920,063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,476,134.82	80,236,263.76
210201	Тэтгэврийн даатгал	53,647,952.21	52,714,418.37
210202	Тэтгэмжийн даатгал	5,967,955.41	6,188,076.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,619,679.35	7,827,121.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,112,777.39	1,298,536.45
210205	Эрүүл мэндийн даатгал	11,127,770.46	12,208,111.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,080,000.00	69,106,454.22
210301	Гэрэл, цахилгаан	5,920,844.22	4,330,523.22
210302	Түлш, халаалт	28,661,855.78	38,001,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,065,300.00	8,342,331.00
210304	Байрны түрээс	18,432,000.00	18,432,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,831,129.00	39,288,011.62
210401	Бичиг хэрэг	6,194,300.00	5,456,200.00
210402	Тээвэр, шатахуун	15,478,419.00	22,469,080.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,674,500.00	6,223,831.62
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,483,910.00	5,138,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	182,867,540.00	257,192,312.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	158,582,140.00	256,347,522.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,285,400.00	844,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,424,330.00	12,774,575.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,142,230.00	4,686,150.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,024,400.00	1,592,625.00
210604	Урсгал засвар	14,257,700.00	6,495,800.00
2107	Томилолт, зочны зардал	10,558,579.00	9,213,500.00
210702	Дотоод албан томилолт	10,558,579.00	9,213,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	755,922,086.50	982,723,526.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	743,679,514.00	980,148,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	918,000.00	771,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	401,572.50	487,722.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	720,000.00
210807	Газрын төлбөр	123,000.00	164,004.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,423,100.00	139,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,423,100.00	139,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	206,833,256.08	176,109,545.90
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,056,459.00	80,697,130.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,364,459.00	79,032,130.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,692,000.00	1,665,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	167,776,797.08	95,412,415.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	167,776,797.08	95,412,415.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,029,960.00	0.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,029,960.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,029,960.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,029,960.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,029,960.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,029,960.00)	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	52,089,327.70	705,567,093.98	757,656,421.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	52,089,327.70	705,567,093.98	757,656,421.68
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-68,839,996.03	-68,839,996.03
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	52,089,327.70	636,727,097.95	688,816,425.65
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	52,089,327.70	636,727,097.95	688,816,425.65
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	52,089,327.70	636,727,097.95	688,816,425.65
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-12,956,487.95	-12,956,487.95
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	52,089,327.70	623,770,610.01	675,859,937.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,307,492,600.00	1,310,259,600.00	100.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,307,492,600.00	1,310,259,600.00	100.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,223,665,400.00	1,136,243,768.10	92.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	658,934,700.00	579,721,432.00	87.98
210101	Үндсэн цалин	466,845,800.00	440,789,796.00	94.42
210102	Нэмэгдэл	138,552,400.00	91,227,913.00	65.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,947,300.00	26,783,660.00	95.84
210104	Урамшуулал	25,589,200.00	20,920,063.00	81.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,708,800.00	80,236,263.76	91.48
210201	Тэтгэврийн даатгал	57,982,100.00	52,714,418.37	90.91
210202	Тэтгэмжийн даатгал	7,016,700.00	6,188,076.55	88.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,273,300.00	7,827,121.16	107.61
210204	Ажилгүйдлийн даатгал	1,403,300.00	1,298,536.45	92.53
210205	Эрүүл мэндийн даатгал	14,033,400.00	12,208,111.23	86.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,192,600.00	69,106,454.22	99.88
210301	Гэрэл, цахилгаан	4,365,100.00	4,330,523.22	99.21
210302	Түлш, халаалт	37,528,800.00	38,001,600.00	101.26
210303	Цэвэр, бохир ус	8,864,700.00	8,342,331.00	94.11
210304	Байрны түрээс	18,434,000.00	18,432,000.00	99.99

2104	Хангамж, бараа материалын зардал	30,905,100.00	30,891,231.62	99.96
210401	Бичиг хэрэг	5,466,200.00	5,456,200.00	99.82
210402	Тээвэр, шатахуун	14,182,300.00	14,072,300.00	99.22
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,127,700.00	6,223,831.62	101.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,128,900.00	5,138,900.00	100.19
2105	Нормативт зардал	28,838,100.00	28,838,085.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,993,300.00	27,993,295.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	844,800.00	844,790.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,774,600.00	12,774,575.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,686,200.00	4,686,150.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,592,600.00	1,592,625.00	100.00
210604	Урсгал засвар	6,495,800.00	6,495,800.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,156,000.00	2,156,000.00	100.00
210702	Дотоод албан томилолт	2,156,000.00	2,156,000.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	333,041,700.00	332,406,726.50	99.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	330,042,600.00	329,831,500.00	99.94
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	771,500.00	771,500.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	499,400.00	487,722.50	97.66
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	720,000.00	100.00
210807	Газрын төлбөр	576,200.00	164,004.00	28.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,827,200.00	174,015,831.90	207.59
213304	Төвлөрүүлэн шилжүүлэг	0.00	93,318,701.90	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	82,135,200.00	79,032,130.00	96.22
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,692,000.00	1,665,000.00	98.40
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,307,492,600.00	1,310,259,600.00	100.21
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,307,492,600.00	1,307,492,600.00	100.00
122005	Орон нутгийн төсвөөс	1,307,492,600.00	1,307,492,600.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	2,767,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,767,000.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0,00	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	896,245,521.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	896,245,521.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	894,151,807.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,396,780.00
210402	Тээвэр, шатахуун	8,396,780.00
2105	Нормативт зардал	228,354,227.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	228,354,227.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-
2107	Томилолт, зочны зардал	7,057,500.00
210702	Дотоод албан томилолт	7,057,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	650,316,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	650,316,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,093,714.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,093,714.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	896,245,521.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	896,245,521.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	646,399,320.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	249,846,201.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мал эмнэлгийн газар нь Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 267 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны А/174 дүгээр тушаалыг үндэслэн 2019 оны 01 дүгээр сарын 02 –ны өдрөөс аймагт Мал эмнэлгийн газар, сумдад мал эмнэлгийн тасаг байгуулагдсан.

Байгууллагын эрхэм зорилгыг мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, аймгийн хэмжээний мал эмнэлгийн төр, хувийн хэвшлийн байгууллагыг нэгдсэн бодлогоор ханган, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад оршино гэж тодорхойлсон.

2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн "Бүтэц, орон тоо батлах тухай" А/24 дугаар тушаалаар аймгийн Мал эмнэлгийн газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Бүтцийн хувьд захиргаа санхүүгийн болон мал амьтны эрүүл мэндийн алба, мал эмнэлгийн лаборатори, Хутаг-өндөр сумын "Гуртын гүүр"-ний мал эмнэлгийн хяналтын цэг, сумдын мал эмнэлгийн тасаг гэсэн, 59 албан хаагчийг орон тоотой байхаар тогтоосон. Тус газар тайлант 16 сумын төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд 55 мал эмнэлэг үйлчилгээний нэгжтэй мал эмнэлгийн арга хэмжээг хэрэгжүүлэх гурвалсан гэрээг байгуулж ажилласан байна.

Тайлант онд шүлхий, үхрийн арьс товруутах, мялзан өвчин гарсан. Лабораторийн хөргөлийн хөргүүр шинээр авч, байр тохижуулсан.

Мал эмнэлгийн газар нь Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, аймгийн хэмжээний мал эмнэлгийн төр, хувийн хэвшлийн байгууллагыг нэгдсэн бодлогоор ханган, нийтийн эрүүл мэндийг хамгаалах эрхэм зорилгын хүрээнд 2022 онд аймгийн Засаг дарга болон МЭЭГ-ын даргатай 14 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 94.5 хувийн биелэлтэйгээр тайлагнасан.

Тайлан оны санхүүгийн тайланд бруцеллёзын тарилга үйлчилгээний хөлсний 3,308.2 мянган төгрөгийн өглөг, улсын тарилга үйлчилгээний хөлсний 26,142.7 мянган төгрөгийн авлагатай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Мал эмнэлгийн газар нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах журам боловсруулж байна.

Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", дотоод журмын заалтыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газар 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа DINAMIK програм ашигладаг.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлгийн газар 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,494.4 төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	303,251.5	312,087.7	8,836.2
Бараа материал	296,051.5	312,087.7	16,036.2
Үндсэн хөрөнгө	385,564.9	393,223.1	7,659.1
Нийт хөрөнгө	688,816.4	705,310.8	16,494.4
Өр төлбөр	0.0	29,450.9	29,450.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	688.816.4	705,310.8	16,494.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	688.816.4	705,310.8	16,494.4

Хүснэгт дэх 2022 оны болон өмнөх оны үзүүлэлтүүдийг харьцуулж гарсан өөрчлөлтийг судлан үзэхэд 5 дансанд 839,762.1 мянган төгрөгийн хандивын барааны авсан нь бараа материалыг 16,036.2 мянган төгрөгөөр буюу эргэлтийн хөрөнгийг 8,836.2 мянган төгрөгөөр өсгөхөд, мөн хандиваар машин тоног төхөөрөмж 45,784.6 мянган, тавилга, эд хогшил 1,243.0 мянган төгрөгийн хөрөнгө авсан нь үндсэн хөрөнгийг 7,659.1 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна..

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд нийт дүнгээрээ 1,546,132.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 238,639.8 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны төсвийг 1,307,492.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд төсвөөс 1,307,492.6 сая төгрөгөөр төлөвлөж баталснаас, нийтдээ 1,214,173.9 мянган санхүүжилт олгож, өөрийн үйлчилгээгээр 2,767.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлого олж, 1,216,940.9 мянган төгрөг буюу 93.1 хувийн зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах

үүрэгтэй. Тайлант онд 896,245.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулж, 2,093.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөлүүдийг тусгасан болно.

Мал эмнэлгийн газар 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улсын төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн нийт зардлын 1,307,492.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,612.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 79,213.3 мянган, тогтмол зардлыг 86.1 мянган, хангамж, бараа материалыг 13.9 мянган хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус хэлтэс 2022 онд шилэн дансны сайтад 147 мэдээлэл байршуулахаас 144-ийг цаг тухай бүрд нь мэдээлсэн ба 3 мэдээлэл хугацаа болоогүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 10 цагаас цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээлэлтэй танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв..

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд Хэрэгжилтийг Төрийн аудитын газарт албан тоотоор 2022 оны 05 сарын 25 ны өдөр хүргүүлсэн байна..

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	0.0	1	0.0	100.0
Зөвлөмж	4	0.0	4	0.0	100.0
Нийт дүн	5	0.0	5	0.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт болон завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 3,551.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулж, эрх зүйн акт зөрчигдсөн² алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Өгсөн зөвлөмж:

Баримтын бүрдлийг хангаж ажиллах

Илрүүлэлт: Зохих зөвшөөрөл, хяналттайгаар бараа материалыг зарлагдсан боловч зарим нь нотлох баримтын бүрдэл дутагдалтай. Тухайбал: Тусгай зориулалтын, эм боох материалын олголтын жагсаалт, авсан хүний гарын үсэг, ажлын гүйцэтгэл, тандалтын ажлын шатахууны тусгайлан бүртгэсэн жагсаалт, ажлын гүйцэтгэлгүй, урсгал засварын ажлыг батлагдсан төсөв, шийдвэргүйгээр материал зарлага гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.4, 13.6, 19.1, 20.1.4, 20.2.6 заалтуудыг хангаж ажиллаагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн актуудын заалтуудыг сайтар судалж, мөрдлөг болгон ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга	1	3,551.7					1	3,551.7				
Эрх зүйн актыг мөрдөөгүй	1	0.0									1	0.0
Дүн	2	3,551.7					1	3,551.7			1	3,551.7

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил	Үүнээс
--	-------------	--------

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Зөрчлийн товч утга			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрх зүйн актыг мөрдөөгүй	1	0.0					1	0.0				
Дүн	1	0.0					1	0.0				